



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 76

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн профайлинг хийх ажлын хүрээнд 18 сум 2 тосгоны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна.

Хөдөлмөр хамгааллын улсын байцаагчийн актаар 2 ажил олгогчоос 46,200.0 мянган төгрөгийн актыг тогтоож төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 4 хөтөлбөрийн хүрээнд 1,168,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 10 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж 84.0 хувиар биелүүлж,

0702000241

биелэлтийг хүргүүлсэн хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	907,580.6	1,622,859.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
Нийт хөрөнгийн дүн	907,580.6	1,622,859.3
Нийт өр төлбөрийн дүн	--	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	907,580.6	1,622,859.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	907,580.6	1,622,859.3
Үйл ажиллагааны орлогын дүн	1,509,890.6	1,994,140.0
Үйл ажиллагааны зардлын дүн	868,034.3	1,260,462.2
Үйл ажиллагааны үр дүн	641,856.3	733,677.8
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	641,856.3	733,677.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	907,580.6	889,181.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	907,580.6	889,181.5
Тайлант оны үр дүн	(18,399.1)	733,677.8
Эцсийн үлдэгдэл	889,181.5	1,622,859.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,509,890.6	1,994,140.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,485,034.3	2,538,410.9
Үйл ажиллагааны ЦМГ	24,856.3	(544,270.9)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	505,452.3	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	480,596.0	544,270.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,399.1	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	480,596.0	1,723,231.3
Урсгал зардал	480,596.0	1,723,231.3
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	480,596.0	1,949,824.0
Улсын төсвөөс санхүүжих	-	450,000.0
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	480,596.0	142,014.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	361,833.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	61,878.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	934,099.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Залруулагдаагүй нийт 31,708.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 31,708.6 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 1,025.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 30,683.6 мянган төгрөгийн 1 зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

1. Зээлийн гэрээ дууссан зээлдэгч нартай холбоотой 1,025.0 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Зээлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн гэрээний хугацаа дууссан боловч төлүүлээгүй зээлийг эргэн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Зээлийн гэрээ дуусаагүй зээлдэгч нартай холбоотой 30,683.6 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", зээлдэгч нартай байгуулсан гэрээний 3.10-т "санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Зээлийн гэрээний хугацаа дуусаагүй боловч хуваарьт хугацаанд төлөгдөөгүй зээлийг төлүүлэх арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	31.7	1	1.0	1	30.7	-	-	-	-	-	-
Дүн	2	31.7	1	1.0	1	30.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/							
			Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			